



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/87/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил Үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	11
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	12
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
Менежментийн захидал	13
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	16
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	23



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БӨМБӨГӨР СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Б.ЧУЛУУНДОРЖ ТАНАА Г

2020.04.27 № 11321
танай _____ -ны № _____ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг үнэлж, Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

005020268



Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээс зарим хөрөнгийг тоолоогүй, худалдан борлуулсны орлого дансанд орсон байхад малыг бүртгэлээс хасаагүй, малын тооны А данс байхгүй, нягтлан бодогч тооллогын бүртгэлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, борлуулсан өвсийг бараа материалаас зарлага гаргаж орлогыг дансанд бүрэн төвлөрүүлээгүй атлаа авлагаар бүртгээгүй, ЗДТГ нь 6007.5 мянган төгрөгийг байгууллагын нярвын харилцах дансаар дамжуулан бэлнээр гарган зарцуулж, холбогдох журам, зааврын дагуу кассын тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыгжилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ", 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ ... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг зөрчсөн байна.

Дээрх нь "Санхүүгийн тайлан дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, ер төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх" гэсэн **Оршин байх**, "Аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх" гэсэн **Тохиолдсон байх**, "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх" гэсэн **Үнэн зөв байдал** гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.1. Оршил

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Б.Чулуундорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 19-нөөс 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлж, аудит хийлгэх тухай албан бичгийг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 87 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Орчин үеийн дэвшилтэт шинэ технологийг ажил албандаа нэвтрүүлж өндөр боловсрол мэргэжилтэй чадварлаг төрийн албаны бүтцээр төрийн үйлчилгээг байгууллага ард иргэдэд түргэн хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэх"-д оршино.

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар нь 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Зорилго-1. Эдийн засгийн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлж, үр ашиг чадавхыг дээшлүүлэн, тогтвортой хөгжлийг хангаж, өөрийгөө тэтгэсэн, бусдаас хараат бус салбаруудтай болох

Зорилго-2. Дэд бүтцийг хөгжүүлэн, бизнесийн хөгжил, айл өрх, иргэдийн амьдралын чанарыг хангах таатай орчин бүрдүүлэх

Зорилго-3. Хүний хөгжлийг дээдэлсэн, иргэнийхээ эрх, боловсрол, соёл, спорт, эрүүл мэндийн хэрэгцээг хангасан төр, нийгмийн үйлчилгээг өөрсдийн нь оролцоонд тулгуурлан хүн бүрд нээлттэй, хүртээмжтэй хүргэх

Зорилго-4. Байгаль орчныг хамгаалж нөөцийг зүй зохистой ашиглан хүний эрүүл орчинд амьдрах эрхийг хангасан тогтвортой хөгжлийг буй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 42 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 4.10 программ хангамж ашигладаг байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 41 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 27 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн, зардлын дүн тэрбум төгрөгөөс дээш дүнтэй тул материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 9440.2 мянган төгрөгөөр тооцсон байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 104657.5 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар буурсан нь тайлант үеийн үр дүн болон дахин үнэлгээтэй хөрөнгө акталснаас дахин үнэлгээний зөрүү данс буурсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-
АВЛАГА	-	7,022.70	7,022.70
БАРАА МАТЕРИАЛ	24,293.40	26,552.80	2,259.40
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,665,202.70	1,634,277.70	(30,925.00)
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(505,963.10)	(588,967.70)	(83,004.60)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,183,533.00	1,078,885.50	(104,647.50)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8.30	72.10	63.80
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,183,524.70	1,078,813.40	(104,711.30)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,183,533.00	1,078,885.50	(104,647.50)

Тус байгууллага Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй оны эцэст 7022.7 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагатай, 72.1 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөгтэй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 2259.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 26552.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба энэ нь байгууллагын үйл ажиллагаатай холбоотой материал өмнөх оноос нэмэгдсэн холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 30925.0 мянган төгрөгөөр буурч оны эцэст 1634277.7 мянган төгрөг болсон нь тайлант онд сумын ИТХ-ын тогтоолоор үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1078813.4 мянган төгрөг болж 104711.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 6 арга хэмжээний зардалд зориулан 313568.5 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, орон нутгийн төсвөөс санхүүжилтийг бүрэн олгожээ.

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлогоор 600.0 мянган төгрөг оруулах төлөвлөгөө өгснийг халуун ус түрээслүүлсний орлогоор 320.0 мянга, ноолуурын орлогоор 280.0 мянган төгрөгийг оруулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ухна ишиг борлуулсны орлогоор 4000.0 мянга, газрын дуудлага худалдааны орлогоор 14575.5 мянга, бичил уурхай эрхлэгчдийн барьцааны төлбөрөөр 10090.0 мянга, эрчим хүчний мөнгийг төвлөрүүлсний хураамжийн орлогоор 4780.0 мянга, ноолуурын орлогоор 525.0 мянга, тендерийн баримт бичгийн үнэнд 495.0 мянга, нийт 34460.5 мянган төгрөг орсон газрын дуудлага худалдааны орлогыг аймагт төвлөрүүлж, 13176.9 мянган төгрөгийг зарцуулан орон нутгийн орлогод 6708.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 41 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 27 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 41 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 12 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 29 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /сая.төг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	0.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	4	16.1	
3	Албан шаардлага өгсөн	3	124.2	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		11	140.7	

Аудитаар нийт 140847.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 16141.1 мянган төгрөгийн 4 алдаанд төлбөрийн акт тогтоож, 124153.6 мянган төгрөгийн 3 алдаанд албан шаардлага өгч, 0.4 мянга төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгав.

Тайлант онд ажиллагсдын цалингаас 1874.7 мянган төгрөг суутгаж, 1897.4 мянган төгрөг шилжүүлж, 22.7 мянган төгрөгийн авлагатай байхад санхүүгийн тайланд авлагыг 127.6 мянган төгрөгөөр илүү тусгаж, оны эцэст ҮЭ-ийн татварын 150.4 мянган төгрөгийн

авлагатай гарсан алдааг санхүүгийн тайланд залруулж, авлагыг 127.6 мянган төгрөгөөр бууруулав.

2.11.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.11.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Зочид төлөөлөгчийн зардлаас 72.0 мянган төгрөгийн согтууруулах ундаа авч, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын хөрөнгөөр согтууруулах ундаа худалдан авахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Сумын ЗДТГ оны эхэнд 4,950,000 төгрөгийн 495 боодол өвсний үлдэгдэлтэй байсан ба сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 оны 11 дүгээр сард нэг бүрийн үнэ нь 10,000 төгрөгийн 152 боодол солоом, 8,000 төгрөгийн 786 боодол өвс, нийт 7,808,000 төгрөгийн өвс, солоом авсныг санхүүгийн тайланд орлогоор бүртгэсэн байна.

Өвс тэжээлийн тайланг нярав гаргаагүй байхад нягтлан бодогч 12 дугаар сард 7,920,000 төгрөгийн өвс, солоомыг зарлагадсан ба санхүүгийн баримтад нярваас олгосон өвс тэжээлийн жагсаалт, хүмүүсийн өвсний мөнгө тушаасан баримт байхгүй байна.

Өвсний үнийг сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлснийг шалгахад 3,740,000 төгрөгийг сумын ОНХС-ийн санд төвлөрүүлсэн, аудитаар зарлагадсан өвс, солоомын үнээс тооцож үзэхэд 4180.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн үнэ төлөгдөөгүй байгаа ба оны эцэст өвс, солоомын үлдэгдлийг тоолоогүй байгаа нь өвсийг худалдан борлуулж, үлдэгдэлгүй болсон гэж үзэхээр байна.

Энэ нь Оршин байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6 дахь “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.3 Балансын данстай холбоотой асуудал

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн данснаас оны эцэст хэмнэгдсэн мөнгөнөөс 2019.12.26-нд "Би Эйч Энд" ХХК-д барилгын материал, засвар нэрээр 7000.0 мянган төгрөг шилжүүлж, санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 1.3 дахь заалт тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.4 Балансын данстай холбоотой асуудал

Тус байгууллагын санхүүгийн тайланд 12380.0 мянган төгрөгийн мал амьтан бүртгэлтэй ба тайлант онд өөрчлөлт ороогүйгээр тайлагнасан байхад нэмэлт санхүүжилтийн дансанд ухна ишиг борлуулсны үнэнд 4000.0 мянга, ноолуурын орлогоор 520.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Мал амьтны орлого, зарлагад хийсэн тайлан, тооцоолол санхүүгийн баримтад байхгүй, малын тоог А дансаар баталгаажуулаагүй, тооллогын бүртгэлд мал тоолоогүй, мал амьтан хорогдсон гэх боловч баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Оршин байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ ... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11.1.5 Балансын данстай холбоотой асуудал

ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2018 онд худалдан авсан 30.0 сая төгрөгийн үнэ бүхий Ланд крейзер 470 маркын суудлын автомашин иргэн С.Баасансүрэнгийн, 35.0 сая төгрөгийн үнэ бүхий Маяти маркын өөрөө буулгагч автомашин иргэн О.Анхболд нэр дээр тус тус бүртгэлтэй байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд газар тариаланд ашиглах зориулалтаар 2018 оны 05 дугаар сарын 10-ний өдөр сумын ЗДТГ-ын дарга, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн гүйцэтгэх захиралтай "Хүнсний ногооны иж бүрдэл зээлээр худалдах, худалдан авах гэрээ" байгуулж, 37.6 сая төгрөгийн үрлүүр, бордоо цацагч, хураагч, 46.8 сая төгрөгийн трактор худалдан авч хөрөнгөд бүртгэсэн байхад 46.8 сая төгрөгийн үнэ бүхий трактор эзэмшигчийн гэрчилгээгүй байна.

Энэ нь Оршин байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ ... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11.1.6 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Оны эцсийн тооллогоор эд хөрөнгийг бүрэн тоолоогүй, мал амьтан худалдан борлуулсан мал амьтныг данснаас хасаагүй, өвс тэжээлийн нягтлан бодох бүртгэлийг тухай бүр бүртгэж, мөнгийг дансанд бүрэн төвлөрүүлээгүй атлаа авлагаар бүртгээгүй зэрэг зөрчил илэрсэн, аудитаар илэрсэн алдааны дүн урьдчилж тогтоосон материаллаг байдлын дүнгээс давсан тул Сөрөг дүгнэлт өгч, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг сумын Засаг дарга Н.Мөнхжаргалд хүргүүлэв.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11.1.7. Дотоод аудит

Байгууллагын нярав Ж.Мөнхжаргал бэлнээр худалдан авалт хийж, 51.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай 25 дугаар зүйлийн 25.6 дахь “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 оны 12 дугаар сард санхүүжигдсэн 6500.0 мянган төгрөгөөр биет бус хөрөнгөд бүртгэсэн “Байр зүйн зураг багуудын хэлийн цэс хэл”-ийг ОНХС-д хийх гүйцэтгэлийн аудитаар тодруулж үзэх шаардлагатай байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудаст оруулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг үнэн зөв байршуулсан эсэхийг шалгахад төсвийн гүйцэтгэлийн 2.3 сарын мэдээллийг буруу мэдээлсэн, 1-р улирлын мэдээг оруулаагүй, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг бүрэн оруулаагүй, мэдээллүүдийг хоцроож мэдээлсэн, мэдээллийг үнэн зөв байршуулаагүй, төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбарыг бичээгүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	10	1	-
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2	2	
4	Сар бүр	3	36	30	6	
5	Тухай бүр	8	96	29	67	
	Нийт	27	151	75	76	-

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулах мэдээллийн 50.3 хувийг хугацаа хоцроож оруулсан, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг тодорхой бичих, мэдээллийг үнэн зөв оруулж, хугацаа мөрдөлтөд сумын санхүүгийн албаны дарга, төсвийн захирагч нар хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1 зөвлөмж өгснийг мөрдөж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Сөрөг” дүгнэлт

Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

